

**ДАРМА БАТБАЯРЫН
БОГИНО ӨГҮҮЛЛЭГИЙН ТУУРВИЛ ЗҮЙН ТУХАЙД**

П. Одсүрэн *

Түлхүүр үг:- өгүүллэгийн хөгжил, богино өгүүллэг, бодрол бясалгалын өгүүллэг, эсээ өгүүллэг, шүлэглэсэн яруу найраг, хураангуй өгүүлэмж-утгын ялгарал, юм үзэгдлийн мөн чанарыг таних, өөрийгөө таних, сэтгэлгээний өгүүллэг, монгол амьдрал

Өгүүллэгийн зохиолын хөгжил нь ардын аман зохиол, бичгийн уран зохиолын уламжлал дээр үүсч үлгэрээс үлгэр-өгүүллэг, үлгэр өгүүллэгээс өгүүллэгийн зохиол ялгаран хөгжихдөө монгол өгүүллэг, туурь болон уран сайхны найруулал нь монгол хүний сэтгэхүйд нэвтэрч, сэтгэлийн хөдөлгөөнийг нээн үзүүлж, зан төрхийг товойлгон дүрсэлж, санаа гүн бөгөөд уран, хэл цэцэн бөгөөд хураангуй, найруулга яруу бөгөөд эгшиглэнтэй бичих урлагийг эзэмшихэд том амжилт олжээ. Д.Нацагдоржийн шүлэглээгүй яруу найраг, өгүүллэг, туурь, С.Буяннэмэхийн романтик өгүүллэг, Д.Цэвэгмидийн хүүрнэл өгүүллэг, Ц.Дамдинсүрэнгийн драматик өгүүллэг, Б.Ринчений түүхэн өгүүллэг, Ч.Лодойдамбын уянгын өгүүллэг, С.Эрдэнийн уянга-сэтгэлзүйн өгүүллэг зэрэг шилдэг бүтээлүүдийн араас Д.Батбаяр нягт өгүүлэмжтэй, гүн санаатай өгүүллэгээрээ монголын уран зохиолд өөрийн байр сууриа нэгэнтээ эзэлсэн билээ.

Зохиолч Д.Батбаяр жүжгийн зохиолоос гадна “Гар” өгүүллэгийн түүврээс хойш тухайн үедээ нэлээд өндөр үнэлэгдсэн “Жаргалын найман морь” /1974 он/, “Аниргүйн эрвээхий” /1983 он/, “Тэнгэрийн царай” /1987 он/, “Айсуй баярын зөн” /1990 он/, “Саахалтын нууранд ангир дуугарна” /1990 он/, “Амрагийн тэнгэр” /2000 он/ гэсэн тууж, дан богино өгүүллэгээс бүрдсэн ном туурвижээ.

Үргэлжилсэн үг тоочин бичих дадлаа сольж хүний дотоод ертөнц, амьдралын нарийн үзэгдэл юмст реалист гүн ажиглалт хийж, түүнээ уран дүрээр нээн үзүүлэх хандлагад шилжсэн [16.263-р тал] тэр үед уран бүтээлийн гараагаа өгүүллэгийн бичлэгийн төрлөөр эхэлж байжээ. “Д.Батбаяр өгүүллэгээрээ авьяастай зохиолч гэж үнэлэгдсэн хүн” гээд түүний анхны уран бүтээлийн тухай ““Жижиг юмаар том санаа гаргана” гэдэг чадвар эзэмших гэж далаад оны залуу өгүүллэгчид ихэд хичээн тэмүүлдэг байсан нь богино өгүүллэгийн Монголын төдийгүй дэлхийн анхаарал татах содон төлөөлөгч С.Эрдэнийн эрэл, тэмүүллээс үүдэлтэй байсан болвуу” гэж судлаач Ч.Билигсайхан өгүүлжээ. Үнэхээр ч Д.Батбаярын зохиол хүний сэтгэл санаанд үл анзаарагдам зүйлийг ургуулан богино хэмжээнд багтаан боловсруулсан туршлага ажиглагддаг билээ.

* “Турван Эрдэнэ” багшийн дээд сургууль

Түүний уран бүтээлийн түүхийг зөвхөн үргэлжилсэн үгийн зохиолын жишээн дээр авч үзвэл 1960-1980-аад он, 1980-2000-гаад он, 2000 оноос хойш үе гэж ангилж болох юм. 1960-1980-аад оны үед туурвиж байсан зохиолын үндсэн сэдэв, санаа нь монголын ахуй амьдрал, хүн зоны хүсэл мөрөөдөл, хүн чанарын тухай, хүний хүнлэг сэтгэл, ёс жудгийн тухай, “монгол өгүүллэгийн ерөнхий хэв намбыг шингээсэн байдалтай [8.19-р тал] найруулгаараа бусдаас содон, амьдралын утга учрыг танихыг эрмэлзсэн гүн бодлоор утга агуулгаа бүрдүүлсэн байхад 1980 оноос хойш бичсэн бүтээлүүд нь хүний дотоод тал руу хандаж, түүний утга учрыг танихыг эрмэлзсэн үзэл санаа бүхий болж гүн ухааны, бодрол бясалгалын аясыг шингээж бичих хандлагатай болсон байна. “1980-аад оноос зохиолч Д.Батбаяр ухаарал бодролын ертөнцөө нууцлагдсан утгад шингээн үзүүлэхийг зорьсон өнгө аястай зохиол бүтээх шинэлэг гэхээр хандлага руу зоригтой орсон юм. [Ч.Билигсайхан.18-р тал] “Монголын уран зохиолын дээж бичиг” номонд “1980-аад оны сүүл 1990-ээд оны үеийн уран бүтээлчид өмнөх үеийн амжилт ололтыг уламжлан авч, өөр өөрийн өвөрмөц бүтээлээ туурвисны дотор хүний дотоод ертөнц рүү өнгийж, түүнийг ийм л байдаг гэх өмнөх тогтсон загвараар өгүүлэх бус харин ч мөн чанараар нь бусдад нээхийг зорьсон Д.Батбаярын тууж, өгүүллэг” [12.169-р тал] гэж онцлон дурдсан нь бий. Утга зохиолыг үзэл суртлын зэвсэг болгож байсан “1980-аад он гэхэд үндсэндээ зохиолчдын сэтгэлгээ, ур чадвар, туурвилзүй үлэмжхэн ядуурч, зохиол бүтээлийн сэдэв, дүр, дүрслэл, зохиомж, өгүүлэмж давтагдан, агуулга явцуурч, хэлбэрийн шинэчлэл үгүй болсон” [1.290-р тал]

Ийм үед Д.Батбаяр өөрийн арга барилаа олсон аж.

Судлаачид 1960-1970-аад онуудад бичиж байсан эхэн үеийн өгүүллэгүүдийг цаг үеийнхээ нөлөөнд байсан гэж үнэлсэн нь учир дутагдалтай юм. Харин ч жинхэнэ уран зохиолыг шүтэн, аль нэг үзэл сурталд автагдаж байгаагүй нь түүний өгүүллэг төдийгүй бусад төрөл зүйлийн бичлэгт дэвшүүлсэн асуудал, зохиолын утга агуулга, дүрийн дотоод яриа, хүсэл мөрөөдлөөс харагдаж байдаг. Судлаач С.Лувсанвандан “Өгүүллэгийг урлах эрдмийн асуудалд” өгүүлэлдээ 1970-аад оны үеийн өгүүллэгийн хөгжлийн төлөвийг үнэлж, Д.Батбаяр ... нарын өгүүллэгүүд нэлээд сонирхолтой болсныг тэмдэглээд дэлгэр утгатай, товч хураангуй, уран санааг яруу дүрслэн үзүүлэх эрдэмд мэргэжиж, туршлага сууж буй нь илэрхий байна гэж дүгнэжээ. [15.226-р тал] Утга зохиол судлаач Ц.Магсар “Айсуй баярын зөн” өгүүлэлдээ “Манай хүүрнэл зохиолд амьдралын мөн чанарын тухай сэдвээр уянгын өгүүллэгийн төрөл зүйл арай илүү чөлөөтэй, үзэл суртлын ямар нэгэн дарамтаас нэлээд ангид бясалган туурвих бололцоотой байжээ гэсэн дүгнэлтийг С.Эрдэнэ, П.Лувсанцэрэн, Д.Батбаяр нарын уран бүтээлээр жишээлэн хэлж болно” [10.344-р тал] гэж бичсэн дүгнэлт зөв зүйтэй юм.

Зохиолч Д.Батбаярын бүтээн туурвих арга, уран сайхны сэтгэлгээний хэв маяг, өнгө төрх нь утга зохиолын “Дөмөн” нэгдлээс үржин төлжсөн “Бишүби” урсгалын “билгээр бясалгах” тунхаглал, үзэл баримтлалтай холбоотой аж. “Энэ урсгалын туйлын зорилго нь хүний төрөлхтөний уран сайхны сэтгэхүйн бодочлох, хийсвэрлэх хоёр замын хэтдээ нийлэх “бэлчир”-ийг “амдан тосох” явдал ажээ”. [1.395-р тал]

“Бишүби” урсгалын онцлог, хөгжлийн түүхэн явцын талаар судлаач Х.Сампилдэндэв “Монголын шинэхэн үеийн яруу найргийн чиг хандлага” [16.68-р тал] өгүүлэлдээ “Бишүбү” бүлгэмийг Д.Урианхай, Д.Батбаяр, Б.Лхагвасүрэн нар бодьгалын сэрэл мэдрэмжийг бичих эрмэлзэлтэй урсгал чиглэлийг санаачилсан нь гадаадын зохиолын хуулбар төдий болсноос бус дэвшүүлсэн зорилт, тунхагтаа дүйцэхүйц бүтээлийг төдий л туурвисангүй...” гэсэн байхад доктор Д.Галбаатар “Монголын уран

зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд” бүтээлдээ нэлээн дэлгэрэнгүй тайлбар хийсэн байдаг бөгөөд “Бишүби”-чүүдийн хийсэн тайлан гэж Д.Батбаярын “Аниргүйн эрвээхий”, “Амрагийн тэнгэр” түүврүүд, “Харуй бүрий” өгүүллэг, “Үхэл миний өмч” жүжгийг тус тус тодотгон нэрлэжээ. [1.396-р тал]

Зохиолч Д.Батбаярын бүтээлийн талаар нэлээн өргөн хүрээтэй, голч дүгнэлт өгсөн ганц бүтээл бол утга зохиол судлаач, эрдэмтэн Ч.Билигсайханы бичсэн “ХХ зууны монгол зохиолчид” цувралын 74 дүгээр боть юм. Уг номонд Дармагийн Батбаярын намтрыг товч дурдаад, уран бүтээлийн талаар чухал санааг дүгнэснээс гадна “Өгүүллэг, бодрол бясалгалын чанартай эсээ зохиолуудыг нарийвчлан судлах шаардлагатай” гэсэн санааг дэвшүүлж хэвлүүлсэн байдаг. Зохиолчийн уран бүтээлийн нэрийн хуудас болсон богино өгүүллэг, зохиолчийн тодотгосноор бэсрэгхэн өгүүллэг, шүлэглээгүй яруу найраг, бодсоноо шивнэхүй, судлаачдын нэрлэснээр уянгын бодрол, зураглал, бичил ойллого, товч, уран бэсрэг өгүүллэгүүд нь судлагдахууны хувьд сонирхолтой, анхаарал татаж байна. Ийм өвөрмөц нэрлэлтүүдийг илэрхийлж байна гэдэг нь уг төрөл зүйлийн онцлог шинжийг шингээсэн бичлэгээр илэрч байгаа зохиолчийн сэтгэлгээний хэв маяг нь ямархуу өвөрмөц арга барилтай болохыг илтгэн харуулж байгаа явдал юм.

Түүний өгүүллэгүүдийг дотоод төрөл зүйлээр нь ангилж үзвэл:-

1. Уянга-сэтгэлзүйн өгүүллэг:- “Айсуй баярын зөн”, “Тэнгэрийн царай”, “Саахалтын нууранд ангир дуугарна”, “Бүрхэг шөнө”, “Гашууны хэдэн тагтаа”,
2. Богино мөртлөө уран бодролууд:- “Өвгөн аавын аяга”, “Бага нас”, “Зүүд2”, “Цасан ширхэг”, “Мартахуй”, “Цаас”, “Зүүд1”, “Навч”, “Дөрвөн бэрх”, “Араншин”, “Сүүдэр”, “Аниргүйн эрвээхий”
3. Эргэцүүлэлт өгүүллэг:- “Үүр тэмдгэрэхийн өмнө”, “Миний чулуу”, “Жигүүр”, “Намрын орой”, “
4. Бодрол-гүн ухааны өгүүллэг:- “Мөнхрөх хүсэл”,
5. Шог өгүүллэг:- “Харуй бүрий”
6. Сэтгэл зүйн өгүүллэг “Хуучин дуу”, “Мэлмий”, “Дундуур дүүрэн”, “Дайны үнэр”,
7. Эсээ өгүүллэг:- “Аргалын гал”, “
8. Сэтгэлзүйн өгүүллэг:-“Хорсол”, “Өглөөний сэрүүн тунгалаг”,
9. Хүүхдийн сэтгэлзүйн өгүүллэг:- “Дайны үнэр”, “Айсуй баярын зөн”, “Гэмшил”, “Ээж”, “Долоон бурхан”,

гэсэн байдлаар ялгарч харагдах ба өгүүллэгүүдийн утга санааны дэвсгэр орон зайг дараах байдлаар ангилж болох юм.

1. Монгол ахуй амьдралын орон зайн дэвсгэр дээрх монгол хүний, тэр дундаа малч ухаантай хүний дүр төрхийг ялгаруулж дүрсэлдэг өгүүллэгүүд
2. Хүний жирийн амьдралын нөхцөл байдлыг гол суурь болгон дүрийнхээ ёс зүйн шинжүүдийг товчлолгон дүрсэлдэг өгүүллэгүүд
3. Маш хураангуй өгүүлэмжийн хүрээнд “том” санааг илэрхийлэн бичдэг гүн ухааны бичлэг бүхий бичвэрүүд

Өгүүллэгүүдийнх нь нийтлэг бичлэгийн онцлог бол аливаа юмс үзэгдлийг тусган бичихдээ зохиолчийн зүгээс эерэг хандлагаар асуудалд ханддаг ерөнхий арга харагддаг. Энэ нь амьдралын саар юмс үзэгдлийг дүрслэхдээ ч гэгээн өнгөөр өнгөлж бичдэг арга барилтай холбоотой. Сайхны тухай үзэл түүний уран бүтээлийн гол ноён нуруу. Тийм ч учраас сайн сайхан руу шунан тэмүүлж байгаа өөдрөг сэтгэлзүйн онцлогтой дүрийг бүтээдэг байна. Тухайлбал “Юм бүхнийг хайрлан ширтэх нүдтэй” “сайхан” дүр

бүтээсэн “Саахалтын нууранд ангир дуугарна” өгүүллэг, төрүүлсэн эхээсээ илүү манцуйлж боосон өрлөг эхээ хүндэтгэх санааг илтгэсэн “Өрлөг эх” өгүүллэгээс гадна “Айсуй баярын зөн” өгүүллэгт дүрслэгдэж буй “*сайхныг бодох тусам эргэн тойрон маань дахиад сайхан болж байх шиг санагдаж*” байгаа, хотын суурин амьдралын хүүхэд багачуудаас эрс ялгаатай, морио шүтэж, мориныхоо аясаар амьдарч байгаа монгол хүүгийн дүрийн хүсэл мөрөөдөл нь айсуй баярын зөнтэй байдаг гэсэн санааг дэвшүүлснээрээ уг зохиолыг өөдрөг болгожээ. Монгол хүүхэд юуг хүсэж, юунд баярладаг тухай өгүүлсэн энэ зохиол монгол ахуйтай, монгол дүрслэлтэй, амны бэлэгдлээс ашдын бэлгэдлийг шүтдэг монгол сэтгэлгээтэй болсноороо онцлог. Монгол морь+Монгол хүн+Монгол хүүхэд+Монгол ахуй гэсэн бүтэцтэй ийм “Магнай хээр”, “Аав эзгүй шөнө”, “Тэнгэрийн царай”, “Тэр зуны бороо ногоо”, “Ширээ хүрэн” өгүүллэгүүд нь нэгэн дүрээр холбогдсон, хэлхсэн утга санаатай, цуврал зохиол маягтай бичигдсэн байна. Түүнчлэн “Харуй бүрий” өгүүллэгийн бэйсийн дүрээр хүний зан төрхийн сөрөг тал болох хоёр нүүр гаргадаг байдлыг үзүүлэхдээ хошин өнгө аясаар ёгтлон бичсэнээрээ уг зохиолын сөрөг санааг уншигчийн сэтгэлийн эерэг сэтгэлзүйн хандлагад шилжүүлж дүрсэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл уншигч гол дүрийн инээдэмт байдлыг шоолж инээх явцдаа хүний зан чанарын сул талыг мэдэрч жигшиж байдаг.

Ёс суртахууны сэдэвтэй “Мэлмий” өгүүллэгтээ эд юмстай харьцаж буй хандлагаар нь дүрээ бүтээсэн бол “Хар тэнгисийн дун” ёсзүйн өгүүллэгт монгол амьдрал, монгол ёс жаягаа үгүйсгэсэн, гадаадын соёлыг хэт шүтэж амьдардаг зарим хүмүүсийг шүүмжилж ёгтолож гаргажээ. Д.Батбаярын өгүүллэгийн талаар “Монголын орчин үеийн уран зохиолын түүх” номны III ботид “...Ёс суртахууны сэдвийг боловсруулахад...Д.Батбаяр... зэрэг зохиолчид шинэ үг, шинэ сэтгэлгээ нэмэрлэн хүний ёс суртахуун, зан чанарын зөрчил дээр тулгуурлан сэтгэлзүйн үүднээс шийдвэрлэх нийтлэг зорилт тавьсан нь уншигчдын анхаарлыг гойд татах чамбай бүтээлүүд гарах бодит нөхцөл бүрэлдүүлсэн билээ” гэж дүгнэжээ. [11.89-р тал]

Зохиолч алив юмсын хоорондын холбоог сайтар гярхай ажиглаж, түүнийгээ уран дүрслэл, уран санаагаар баяжуулж бичдэг арга барилтай юм. Тухайлбал “Өвгөн аавын аяга” өгүүллэгт аяга-аяган доторх тооно, тоононд багтах тэнгэр гэсэн бүтцийн хүрээнд өвөг аавынхаа аяганаас уух хүсэлтэй хүүгийн дүрийг бүтээжээ. Аяга нь өвөг аавын гэдэг утгаараа хүндэтгэлийн өнгө аяс, аягыг сар шахуу цохиж мөнгөлсөн гэдэг утгаараа үнэ цэн-хайрын хүчийг урнаар далдлан бичсэнээс гадна аягыг булаалдахад айраг цалгилан, аяган дотор багтаж байсан гэрийн тооно дайвалзан, цаашлаад тэнгэрийг юмшуулан аяга болон тоонон дотор багтаж байсан тэнгэр бутран унаж байгаа гэсэн ахиулсан дүрслэлээр “дээшээ, өөдөө” гэсэн бэлгэдэлт сэтгэлгээг уламжлан авч хүндлэн дээдлэх санааг гаргажээ. Мөнгөн аягаар төлөөлсөн монгол хүний орших үндэс болох ахуйн болон эдийн соёл, тооноор төлөөлсөн монгол хүний оршин байх гэр ахуй, тэнгэрээр төлөөлсөн байгаль дэлхий гээд энэ бүх тойрог дүрс бүхий бэлгэдлүүд маань эргээд тэнгэрээс тооно руу, тоононоос аяга руу гэсэн байдлаар хувь хүний оршихуйгаас эх дэлхий, хүн хоёрын харилцааг илэрхийлж байгаа нь гайхалтай уран шийдэл болсон юм. Өвөг дээдсээсээ байгаль, эх дэлхий, тэнгэрээ шүтэж байсан арга ухааныг аяган доторх айргаар төлөөлж бэлгэдсэн нь уг зохиолын өгүүлэмжийн уран санаа болжээ. Аягатай бол ундтай гэж ярилцдаг, дээшээ харсан амсартай савыг бэлгэшээн үздэг өвөрмөц сэтгэлгээнээс болон далд ухамсраар илрэх зан үйлээс ургуулан энэхүү өгүүллэгийг логик дэс дараатай, сургамжтай байдлаар бүтээжээ.

Зохиолчийн урлан бүтээх гол арга бол бэлгэдлийн арга юм. “1970-аад оноос Д.Батбаяр, Д.Төрбат, Д.Цоодол, Ш.Сүрэнжав, Б.Лхагвасүрэн, Д.Урианхайн туульсын болон яруу найрагт бэлгэчлэн дүрслэх аргыг өргөн хэрэглэж байгаа [1.373-р тал] нь түүний олон бүтээлд тусгалаа олсон байдаг. Бэлгэдэлт чанар нь аажмаар гүнзгийрэн утга санаа, дүр, зан төрх, зөрчил тэмцлийг бэлгэдэн үзүүлэх гүн, нарийн утгатай болж иржээ. “Хаа нэгтэйгээс будгийн үнэр ханхална. Хуучин шаргал өнгийг нь дарах гэж хурц улаанаар будсан байх гэж бодогдоход үзээ ч үгүй шаргал өнгө дурсамж болно. Үзэх ч магадгүй улаан өнгө хүслэн болно. Болдог сон бол аль алиныг нь дараад будчих юмсан. Байгаа өнгө минь хараас өөр юу ч билээ дээ” энэ шүлгийн “хуучин шаргал” нь шашны, “хурц улаан” нь хувьсгалын, улмаар энэ хоёрын зөрчил тэмцлийг бэлгэджээ” гэж бэлгэдлийн ур маягаар бүтсэн болох талаас нь судлаач Б.Мөнхбаяр тайлбарлажээ. [13.194-р тал]

Зохиолч Д.Батбаярын бүтээсэн зохиолуудыг он цагийн дэс дарааллаар харахад зохиолынхоо хийцийг улам шинэ болгох, өөр санаа дэвшүүлэхийг эрмэлздэг болох нь ажиглагдаж байна.

Өгүүллэгүүдийн дүрийн харьцаа, түүгээр илэрч байгаа зохиолчийн эргэцүүлэмж нь ихэвчлэн тэгш хэмтэй мөртлөө зөрчилт талыг нээх замаар илэрдэг байна. Ихэнх зохиол нь хосмолжин бүтэцтэй байна. Тухайлбал “Дундуур дүүрэн” өгүүллэгт мандаж байгаа нар, шингэж байгаа нарны тусах байдлаар эсрэгцсэн дүрийн сэтгэлзүйг нээсэн байхад “Хорсол” зохиолд хаяад явсан эхнэрээ амьтнаар орлуулж, гөлөг гэж адилтган, эсрэгцсэн хоёр өөр дүрээр /хүн-амьтан/ гол дүр Самбуугийн сэтгэлзүйн зөрчлийг харуулж бичсэн байна. Мөн “Ээж” өгүүллэгт эх хүний үрээ гэсэн халуун сэтгэлийг харуулахдаа ахын дүртэй эсрэгцүүлэхийн зэрэгцээ улирлын байдал болон ээж ах хоёрын хүүхдэд харьцах харьцаагаар, тэдний хэлж байгаа хэдхэн үйл үгээр давхар давхар өгүүлэмж үүсгэн эсрэгцүүлжээ.

Ээж	Ах
Зуны шөнө	Намрын шөнө
Дуулдахын төдий, уруул хөдлөхийн төдий, сонстохын төдий “Айсан уу” гэж шивнэн асуусан	Ах нь юу ч яриагүй, айсан уу гэж асуугаагүй
Тэнгэрийн хаяа руу од харвав	Тэнгэрийн тэнхлэг рүү од харвав
Миний хүү урьдаар нулим гэж хэлсэн	Ах харваж буй одыг анзаараагүй, харин хүү ээжийгээ бодсон
Хүүгээ баруун, зүүн талдаа хөтөлсөн	Ах нь түрүүлж алхсан, дүү нь бүдэрч унана

Зуны шөнө ээжтэйгээ алхаж яваа хүү тэнгэрт од харвахад ээжийнхээ “урьдаар нулим” гэснийг ойлгохын цаана эхийн сайхан сэтгэл илэрч байгаа бол намрын шөнө ахтайгаа явж байхдаа харваж байгаа одны өмнөөс “Ээжийн од биш!, Түй” гэж хэлсний цаана ээжийгээ хайрлах хүүгийн хайр тодрохын зэрэгцээ ээжийнх нь хайраар ах нь хайрлаж чадахгүй байгаагаар тус тус эсрэгцүүлжээ. Ингэхдээ зун, намрын улирлын байдлыг үнэлэх монголчуудын сэтгэлгээний үнэлэмж давхар илэрчээ.

Д.Батбаяр өгүүллэгээс гадна тууж, жүжгийн зохиолдоо хүүхдийн дүрийг голлох байр суурьтай болгон хүүхдийн сэтгэлзүйн онцлогийг үйл явдлынхаа үндсэн өгүүлэмжийг бүрдүүлэхдээ ашиглаж бичдэг туурвилзүйтэй зохиолч аж. Суга таягтай Алимаа охиныг өрөвдөн хайрлах сэтгэлтэй нэгэн хүүгийн энэрэнгүй бодол санааг онцолж дүрслэхдээ гартаа наалдсан эрвээхэйн нэг далавчны хүрэн улаан будаг шиг өнгө наалдсан байхыг хараад сэтгэл нь эмзэглэж, өөрөөс нь болж Алимаа суга таягтай болсон шиг санагдаж байгаагаар үзүүлжээ. Нэг даль жигүүрээ гэсэн эрвээхэйг хөөрхий

охинтой адилтгах аргаар хүмүүнлэг үзэл санааг маш энгийн, илүү дутуу чимэг үггүй, оновчтой уран санаагаар илтгэсэн байна. Монгол хүүхдийн өсөж өндийж ирсэн уламжлалт амьдралыг харуулсан “Өрлөг эх”, “Хүүхдийн хувь” зэрэг зохиолд зөв хүүхдийн төрх байдлаас эхлээд зөв хэл яриа, зөв үзэл бодол, зөв хүсэл мөрөөдлийг бичихдээ гэгээн бодол тээсэн хэмээн дүрээ тодотгожээ.

Зарим өгүүллэгт нь эмэгтэй хүний сэтгэлзүйн онцлог, дотоод шаналал, амьдралд их хайрыг хүссэнээсээ болсон уу эсвэл хайрлаж чадахгүйдээ цөхөрч байгаа сэтгэцийн өвөрмөц байдлыг давхар зөрчил болгон дэвшүүлж тавьдаг онцлог илэрнэ. “Нэргүй” өгүүллэгт нөхрөө хэл үггүй алга болж ирэхээр нь хатуу үг чулуудаж чадахгүйдээ шаналж, өөрийн сэтгэлийн зовлонгоо барьж ядахдаа *“арван жилийн охидын оёдог цэцгэрхүү юм”* оёж байгаа эмэгтэй хүний эр нөхрөө үзэн ядахын зовлонгоо хайрлахын учгаар солин, байж ядаж буй сэтгэлийн дотоод зөрчлийг үзүүлжээ. Ингэхдээ айлын хүндээ оёж байгаа зүйлээ үзүүлж *“Миний энэн дотор хэн ч олж хардаггүй хар утас байгаа. Энэ утас бүх хээг чимж байгаа юм”* гэж тайлбарласнаас үзэхэд зохиолч дүрийнхээ нөхрөө хардаж байгаа нууцлагдмал сэтгэлийн өнгийг, мөн амьдралд нь тэрхүү хар утас шиг хар толбо байгааг олж харж, ялгаж чадсандаа бахархаж байгаа байдлыг далд бэлгэдлийн аргаар дүрсэлсэн нь уг зохиолыг уран болгосон гэж дүгнэж болно. Уншихад маш энгийн, хоёр хүний хоорондох харьцааг өгүүлсэн атал эмэгтэй хүний үйл мэтгэж, түүндээ автан цаг зуурын тайвшралыг олж чаддаг сэтгэлийн эмзэг нандин байдлыг богинохон үйл явдлын холбоос дунд маш их зүйлийг бодогдуулахаар бичсэн байна.

Оёсон цэцэгний өчүүхэн хар зураасаар ёгтлон бэлгэдэж, “том” утга санааг ургуулан дүрсэлсэн энэ зохиолоос харахад зохиолч С.Эрдэнэ, Д.Намдаг нарын энгийн зүйлээс ургуулан бодож бясалган тунгааж, дүрийн дотоод сэтгэлийн нарийн нандин руу ханддаг арга барилаас суралцсан нь тодорхой юм. С.Эрдэнэ “Өгүүллэг бол нуршаа үг, хуурамч өнгөөр ер бүтэхгүй, элдвийг чихэх зай завсар ч байхгүй, өгүүллэг бол уран нарийний хувьд яруу найрагт дөхөж очно” гэж “Өгүүллэгийн амин сүнс” гэсэн бодол эргэцүүлэлдээ бичжээ. Д.Батбаярын өгүүллэгүүд өмнөх үеийнхнээсээ улам зай завсаргүй болгож, улам нягтруулж чадсанд түүний ур чадварын нээлт тодорно.

Нөгөө талаараа 1960-1970-аад оны богино өгүүллэгийн бичлэгт үйл явдлыг хөөдөг тогтсон хэвшлийг эвдэж, дүрийнхээ дотоод сэтгэхүйн талыг гүнзгий мэдэрч задлан шинжлэн бичдэг арга барилаас [18.239-р тал] суралцсан нь илт.

Эмэгтэй хүний сэтгэлзүйн эмзэг байдлыг харуулсан “Гашууны хэдэн тагтаа” өгүүллэг нь уран чадварын хувьд сайн боловсруулалттай, амьд өрнөлттэй, өвөрмөц шийдэлтэй зохиол юм. Хэн нэгэнд дурлаж догдолсон эгчид нь татсан солонго, гашуун ногоог хээв нэг зулгаан хэвтэн, гоё юм хэмээн уулга алдаж байгаа байдлаар хүний үл ухамсарлахуйгаар бий болсон сэтгэлзүйн догдлолыг нэг талаас, нөгөө талаас эгчийнхээ нууцыг хадгалж чадсандаа баярлаж байгаа гэнэн, цагаан, үнэнч сэтгэлтэй дүүгийнх нь зан төрхийн ялгарлыг ямар нэгэн “нууц” юманд зангидаж, тэрхүү “нууц”-ыг зохиолч зохиолын төгсгөлд *“гашууны хэдэн тагтаа газар унагалгүй шүүрч аваад тэнгэрт гарчихсан юм шиг ор сураггүй алга болж”* байгаагаар зохиомжлон чухамдаа хүний харьцаан дахь /эгч-үл таних хүн хоёрын/ зөрчлийн нууц нь юунд оршиж байдгийг, мөн эсвэл хүний харьцааны /эгч-дүү хоёрын/ сайн сайхан чанар нь юунд оршиж байдгийг уран сайхны аргаар далдлан дүрсэлсэн нь уг зохиолын гоо сайхны үнэ цэн нь оршиж байна. “Нууц”-ыг уншигч өөрөө бодолт хийн гаргах учиртай гэсэн гаргалгаа энэ өгүүллэгт илэрнэ. Зохиолын хамгийн гол чанар нь дүрийн урлал дээр ялгарна. Зохиолч

хүүгийн дүрийн гэнэн, сайхан сэтгэлт зан чанартай нь холбож, гарынхаа алганд эгчийнхээ нууцыг хадгалж, нууцынх нь үнэр нь хүртэл арилчихвий гэж гараа угаахгүй байгаа байдлаар зохиомжилсон нь итгэл үнэмшилтэй дүр болж чадсан юм. Зохиолд нэг хүн гол дүр байдаг гэсэн ерөнхий загвараас ангид эгч дүү хоёрын дүр хоёулаа гол, зохиолын зангилааг үүсгэсэн дүрийг бүтээснээрээ өвөрмөц болжээ. Энэ мэтээр түүний зохиолууд нь богинохон нягт өгүүлэмжид маш тодорхой гүн санааг агуулж чаддагаараа шинэ юм.

Өгүүлэмжээрээ нягт, илүү дутуу зүйлгүй, товч тодорхой, нарийн дүрслэлтэй бичдэг хэмээн үнэлэгддэг Д.Нацагдорж, П.Лувсанцэрэн, С.Эрдэнэ нарын тэрхүү бичлэгийн уламжлалыг залгамжлуулахдаа улам хураангуй болгон, улам гүн санаа шингээсэн нь олон богино хэлбэрийн үргэлжилсэн зохиолуудаас нь ажиглагддаг. Эрдэмтэн судлаач Х.Сампилдэндэв “П.Лувсанцэрэнгийн сэтгэлзүйн өгүүллэгийн төрөл хэлбэрийг залгамж үеийн зохиолчид уран сайхны эрэл нээлтээр баяжуулсан билээ” гээд Д.Намдаг, Ч.Лодойдамба, Б.Бааст, С.Дашдооров, Л.Түдэв, Д.Маам, С.Пүрэв, Б.Догмид, Д.Гармаа, Ж.Дашзэвэг, Д.Норов, П.Баярсайхан нарын Д.Батбаярын “Мэлмий”, “Гашууны хэдэн тагтаа” зохиолыг онцлон дурдсан байдаг. [18.240-р тал]

Гүн ухааны өнгө аястай зохиолуудаас “Аниргүй эрвээхий”, “Мөнхрөх хүсэл”, “Мартахуй”, “Зүүд1” зэрэг нь ялгарч байна. Зохиолч Д.Батбаярын уран бүтээлийн өнгө нь гэгээн гэрэлтэй байхаас гадна дуу чимээ багатай, аниргүй, нам гүм, тайван амгалан шинж аль ч зохиолд нь тодордог. Ялангуяа гүн ухаан, гүн сэтгэлгээнээс төрсөн бичил эхүүд нь бүр ч аниргүй, тэгсэн мөртлөө хүчтэй мэдрэмж төрүүлж чаддаг байна. “Аниргүйн эрвээхий” бүтээлд эрвээхий хүн хоёрын харилцан мэтгэлцээнээр дамжуулж, бэлгэдлийн ур маягийг шингээн мөнх оршихуй, мөнх бусын оршихуйг эсрэгцүүлж бичжээ. Хүүрнэл зохиолд хүн төрөлхтөний оршихуйн асуудал, гүн ухааны бодрол, бясалгал давамгайлж, оюун сэтгэхүйн чиглэл рүү зорьсон бичлэг голлох [13.289-р тал] хандлага уг зохиолд илэрчээ.

Харанхуй гэрэл хоёрын зөрчлийн дэвсгэр дээр эргэн тойрны нам гүм байдлыг мөнх оршихуйтай зүйрлэн хязгааргүй гэж тодотгосон нь зохиолчийн илэрхийлэх гол санааны зангилаа цөм утгыг илтгэжээ. Харанхуйгаас зугтсан эрвээхий гэдэг бол хоосонгоос зугатсан гэсэн үг. Гэвч тэрхүү харанхуй, хоосон гэгч нь цаанаа амьдралын сайн сайхныг, гэрэл гэгээг ялгах өнгө байсныг хөөрхий эрвээхэй мэдсэнгүй, харин хүн тэр мөн чанарыг таньж чадаж байгаагаар өгүүлсэн байна. Харанхуй, хоосон байгаа шинж байдлыг ахиулан дүрслэхдээ нам гүм гэж тодотгоод, улмаар мөнхөд хязгааргүй байх мэт сэтгэгдлийг төрүүлдэг. Эрвээхийг гэрэлнээс хол байхыг хүссэн хүн харанхуйн буюу нам гүм, мөнх оршихуйн мөн чанарыг таньсан учраас тийнхүү зөвлөж байдаг. Энэ нь угтаа цаанаа “харанхуйд” л хүн өөрийгөө сонсож, өөрийгөө мэдэрч чаддаг гэсэн өвөрмөц гаргалгаа илэрч байгаа бөгөөд зохиолчийн “Үүр тэмдгэрэхийн өмнө” өгүүллэгт дүрсэлсэн санааны нэг хувилбар гэж үзэж болно. Зохиолчийн түрүү үеийн зохиолуудад гарч байсан “нөхцөлүүд” хожмын зохиолуудад нь “бэлгэдэл” болж хувирсан байна.

Гэрэл тойрон дэрвэлзэж нисэж яваа эрвээхийн “Холдохгүй, холдвол орчлонгийн хоосон гэгч бүхнийг эзэлнэ. Энэ бол хоосонтой тулалдаж байгаа миний тулалдаан. Хоосонтой булаацалдаж байгаа миний үнэн” гэж хэлсэн үг зохиолчийн зөрчлийн туйлыг илтгэж байна. Энэ эхэд нэг талаас зохиолч, эсрэг талаас эрвээхий хоёр гэрэл харанхуйг эзлэн зөрчилдөж байгаа хэдий ч далд утгандаа хүний орших эсвэл үл орших мөн чанарын үнэнг дэлгэж тавьсан билээ. Ертөнцөд хүн хоосонг шүтэх эсвэл гэрэл

мөнхөд байгааг шүтэх бус энэхүү харанхуй гэрэл гэсэн хоёр ойлголт, түүний мөн чанар зэрэгцэж, эсвэл эсрэгцэж байж хүн өөрөө тогтнодог юм гэсэн зохиолчийн далд санаа илэрсэн бололтой. Эрвээхий гэрэл өөд тэмүүлэх нь зөв бас үнэн гэсэн санаа ч байж магадгүй. Алдарт яруу найрагч Б.Явуухулангийн “Харахаас ялдам хонгор бүсгүй” шүлгийн санааг дэлгэрүүлсэн гэлтэй энэ бичил эхэд хүсэл, хяслын тэнцэх жам хуулийг цаг хугацааны ойлголтоор баяжуулан зохиосон байна. Юунд цаг хугацаа алдаж байгаагаа үл ухааран дөл рүү яаран тэмүүлж эцэс сүүлдээ харанхуйд живж байгаа эрвээхийн дүрээр их хүсэж шунавал тэрхүү далайдаа живдэг гэсэн санааг гаргасан байна. Эрвээхий угтаа гэрэл, хоосон хоёрыг хоёуланг нь ялгах тэнхээтэй байх ёстой байж гэсэн далд бодомжийг зохиолч давхар санаа болгон хийсвэрлэн зохиомжлон бичжээ. Ер нь зохиолчийн ихэнх бичил зохиолууд хийсвэрлэх аргаар бичигдсэн нь шинэ сонин зүйл юм. “1930-аад оноос монгол хэв маягийн абстракционизм буюу хийсвэрчлэн ондоошуулж дүрслэх үзлийн уламжлалт арга бүрэлдэн тогтож байсан ч дэлхийн II дайны дараа үеэс 1980 оны дунд үеийг хүртэл энэхүү аргын уран зохиол хөгжих орон зай, таатай нөхцөл олдоогүй бөгөөд үргэлжилсэн зохиол, яруу найрагт дүрслэх хэрэглүүрийн түвшинд хавсарга шинжтэй ч чухал үүрэг гүйцэтгэсээр ирснийг Д.Урианхайн шүлэг, Д.Батбаярын бичил ойллого, богино өгүүллэг, ... нарын бүтээлийн өвөрмөц хэлбэр, гүн хийсвэрлэл харуулдаг” [1.290-р тал]

Зохиолчийн бясалгаж, эргэцүүлсний охь дээж болсон гүн ухааны шинжтэй богино өгүүллэгүүд, бодролууд, эргэцүүлүүд түүний уран бүтээлд чухал байр суурьтай. Монголын үргэлжилсэн зохиолын бага төрөлд “үг”, “яриа” гэж бий. Харин Д.Батбаяр ойллого, шүлэглэсэн яруу найраг, шивнэсэн үг гэх мэт бага төрлийг хөгжүүлж байгаагаар нь шинэчлэлийн салхийг дэрвүүлж явна гэж ойлгож болох юм. Монгол бичгийн уран зохиолд үргэлжилсэн үгийн ийм бага төрөл сонгодог утгаараа төдий л хөгжөөгүй нөхцөлд тухайн хэлбэрийн жишгийг тогтоох үндсийг тавьж байна.

Гүнзгий, утга төгөлдөр санааг энгийн хэдхэн өгүүлбэрт багтаан, уншигчид зохиолын утгыг тогтоон байж ухаарахын мөн чанарыг шингээх байдлаар илтгэж бичнэ гэдэг нь уг зохиолчийн урлан бүтээх авьяас, үргэлжийн мөнхийн ухаан бодлоороо өөрөө өөртэйгээ ярилцаж, өөрийгөө сонссоны үр шимтэй холбоотой аж. Ийм хэлбэрийн бүтээлүүдэд тодорхой дүр байхгүй атал зохиолчийн дүр байдал, зан чанар, ертөнцийг үзэх үзэл, ааш авир, сэтгэлийн хүч нь цогцолж “өвөрмөц” дүр буюу “зохиолч дүр” бий болсон нь харагддаг. Өөрөөр хэлбэл зохиолоос харахад зохиолчийн өөрийгөө олсон утга учир тодордог юм.

Түүнчлэн утга гүнзгий, эргэцүүлэлт санааны ил хэлбэрээс уншигч мөн өөрийнхөө хэн гэдгийг олж хардаг бас нэгэн дүр болж буудаг байна. Энэ төрөл зүйлд хамаарах олон зохиол байх бөгөөд тэдгээрийн бичлэг, арга найруулгын хувьд нийтлэг шинжийг тодотгон үзвэл:-

1. Эргэцүүлэмж найруулгын хэв маягаар зохиолч үзэл бодлоо илтгэсэн байдаг. Ингэхдээ нэг утгаас дараагийн утга тодрон гарах замаар ургуулан бясалгаж, дотоод зүй тогтол, логикийг эрхэмлэдэг нь тод ажиглагддаг.

2. Ертөнц болоод хүний мөн чанарыг танихыг эрмэлзсэн, түүндээ өөрөө асуулт тавин хариулах маягаар эргэцүүлж бичдэг арга зонхилдог.

3. Гүн гүнзгий утга санааг цөөхөн энгийн өгүүлбэрт “багтаан” илэрхийлж чаддаг зохиолчийн ур ухаан харагдана. Ерөөс энэ нь жинхэнэ монгол ухаан болох “үхрийн махыг үнхэлцэгэнд нь багтаадаг” ахуйгаас үүдэлтэй уламжлалт сэтгэлгээнээс суралцсан буюу зохиолч байгалиас бэлэглэсэн зөн билгээрээ аливаад хандаж ирсэнтэй холбоотой

гэж үзэж байна. Монгол аман зохиолын бага хэмжээний төрөл зүйлүүд үүнийг илтгэнэ. “Түүний богино хэлбэрийн бүтээл нь “зүйр цэцэн үг, мэргэдийн мөр сургаал шиг цэгцрэн товчлогдож, санаа нь гүнзгийрсэн” [8.20-р тал] байдлаараа монголын үргэлжилсэн зохиолын туурвилзүйн хөгжилд үнэтэй байр эзэлнэ.

4. Бодрол, эргэцүүллийн эдгээр төрөл зүйлийн онцлог шинжүүд нь монголын уран зохиолын түүхийн хөгжлийн 19 дүгээр зууны соён гэгээрүүлэгчдийн бүтээлд илэрч байсан бөгөөд энэхүү уламжлалыг зохиолч Д.Батбаяр хөгжүүлж, сэтгэлийн дотоод талыг нээх биш зүгээр л дэлгэж тавихыг зорьж бичсэнээрээ ялгагдана.

5. Зохиолчийн хэлснээр “сэтгэлээр шинжилж, шивнэсэн” эдгээр бүтээлүүдийн өгүүлэгдэж байгаа зүйлсийн харьцаа нь хүн-байгаль, хүн-ертөнц, эх хүн-үр хүүхэд, монгол амьдрал-монгол хүн, мөнх-мөнх бусын гэх мэт үүдэл санаагаар биежиж төгөлдөржсөн байдаг.

6. Зохиолч маш их уншиж эргэцүүлсний үр дүнд бий болсон гэмээр бичил эхүүдийг ертөнц, хүний амьдралын нэгэн үгэн хувилбар, үнэнд дөхсөн үгсийн зөв байршил, хэн нэгэн хүний хэлсэн онч санаа бүхий үгийг дэлгэрүүлж бичсэн хувилбар ч гэж үзэж болохоор байдаг. Өөрөөр хэлбэл зохиолч ертөнцийн элдэв зүйлсээс сэрж мэдэрч, өөрт нь хүчтэй сэтгэгдэл төрсөн тэр л агшнаас санаа нь төрдөг гэмээр бичлэгийн арга ажиглагддаг. Энэ утгаараа байгалийн өгөгдөхүүнийг яруу найраг болгож байгаа зарчимтай төстэй гэмээр аргаар бичсэн гэж болно. Тиймдээ ч зохиолч өөрөө шүлэглээгүй яруу найраг гэж нэрлэсэн нь бий. Судлаач Ч.Билигсайхан “Ер нь Д.Батбаяр ясны яруу найрагчийн хараа, сэрэл сэтгэлгээтэй зохиолч. Харин тэр нь заримдаа шүлэглэсэн, заримдаа шүлэглээгүй өгүүлсэн маягаар илэрсэн нь бий” гэжээ.

7. Бичил эхүүд нь агуулга нь ойлгомжтой, тодорхой дүртэй зохиолыг бодоход юу хэлэх нь тодорхой бус тийм хаос шинжтэй, оньсого шиг байгаа нь зохиолч хэлэх гэсэн зорьсон санаагаа зөрчилт бодлоор хэлхсэн үг, өгүүлбэрт олон талаас нь эргэцүүлж бясалгасан далд санааг шингээсэнтэй холбоотой юм. Үүнийг түүний бичлэгийн үндсэн арга барил гэж үзэж болно. Тиймэрхүү зохиолыг уншихад бодолт үүсч, уншигчид өвөрмөц санааг ургуулан оюун бодлын цэнгэл амсаж байдаг билээ. “Зохиолч бичлэгийн арга барилтай болох зүйн хэрэг, тэргүйгээр ямар шинэчлэл байх билээ” [14.345-р тал]

8. Нэлээд боловсронгуй болсон бичил эхүүдэд анализ хийвэл текстийг бүрдүүлж байгаа үгийн холбоосууд нь маш нарийн бүтцээр, давхар давхар санааг шигтгэн зохион байгуулагдсан байдаг. Тухайлбал: “Бага нас” бичил эхэд цас лавсах, ногоо ургах, бороо шаагих, шувуу буцах байгалийн үзэгдэл юмсын онцлог байдлыг монгол хүүхдийн өссөн орчин, 4 улирал дахь ажил хөдөлмөрийн байдалд хандаж байгаа сэтгэлзүйн онцлогтой холбон, улмаар аав, ээж, өвөө, эмээгийн улирлын өнгө төрхтэй уялдсан ааш аяг болон хүүтэй харьцах харьцаа гэх зэргийг эн тэнцүүлэх зарчмаар зэрэгцүүлэн өгүүлэхдээ дүрүүдийн хоорондох зөрчил, түүний шалтаг шалтгааны мөн чанарыг шагай няслах, чулуун тоглоом, морь уралдах, аргал түүх гэсэн монгол ахуйтай холбосон нь нэн өвөрмөц, чамбай болсон бүтээл гэж үзэх үндэстэй юм. Улирал бүрд илэрч байгаа хүүгийн сэтгэл хөдлөл нь тухайн улирлын үндсэн онцлогийг илтгэн гаргах бөгөөд тэр гэр бүлийн хийж байгаа үйл нь хүртэл дөрвөн улирлын байдалтай холбогдсон нь уран юм. Цас лавсахад шагай дандаа тэмээ бууна, ногоо ургахад чулуун тоглоом олон олон болно гэх зэргээр монголчуудын улиралд хандах хандлагын цаана хүүхдийн дотоод сэтгэлийн өнгийг нууцлан үгээр тойруулан илэрхийлж чадсан байна. Ч.Билигсайхан “Элит зохиолчийг эцэг тэнгэр ивээнэ” өгүүлэлдээ “Жинхэнэ уран зохиолыг бүтээх гол

арга нь харьцуулал, задлал, нэгтгэл, дүгнэлт, шүүн бодохуй, эргэцүүлэл, таамаглал зэрэг оюун сэтгэлгээний дээд үйлдлийг сэтгэлийн авьяастай нийцүүлэн илэрхийлэх явдал болжээ. Ийм байдлаар жинхэнэ уран зохиол гоёчлол, бэлэнчлэл, сэтгэлийн хөөрөл ховордож бодол ухаарал зонхилох боллоо” [9.267-р тал] гэжээ.

Дүгнэлт

1. Монгол өгүүллэгийн хөгжилд гүн сэтгэлгээ, бодрол, эргэцүүллийн өнгө аясыг төгөлдөржүүлж, нягт өгүүлэмжээр гүн санаа илэрхийлдэг бага хэмжээний төрөл зүйлийг бий болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан зохиолч болохоо харууллаа.
2. Зохиолч Д.Батбаяр үзэл сурталд авталгүй бичдэг, өөрийгөө болон бусдын хүн сэтгэлийг нээж бичих зорилго өвөрлөсөн, түүндээ үнэнч ханддаг хувь хүн юм.
3. Эхэн үедээ бичсэн өгүүллэгүүд нь дорнын өнгө аясыг хадгалсан байхад сүүл үеийн зохиолууд нь өрнийн философийн мөн чанарыг хадгалсан атлаа дотогшоо гүнзгийрч ухааран сэтгэдэг монгол хүний зан төрхөөр бүтээлээ туурвисан байна.
4. Зөрчлөөс үүдсэн эргэцүүлэл нь зохиолчийн гол туурвилзүй юм.
5. Зохиолууд нь өөдрөг үзлээс бүтсэн, дотоод мэдрэмжийн илэрхийлэл болсон зохиолууд зонхилж байна.
6. Зохиолын уран дүрслэлүүд нь монгол сэтгэлгээний уламжлалаас бүтсэн онцлогтой.
7. Үргэлжилсэн хэлбэрийн зохиолуудад нь шинэ дүр ховор ч бичил эхүүдэд нь зохиолчийн өөрийн байр суурь нь дүрийн шинжийг агуулж байгаагаараа өвөрмөц юм.
8. Богино хэмжээний өгүүллэгүүдэд нь зохиолчийн санаа ил тод илэрснээс гадна бичил эхүүдэд нь зохиолчийн санаа далд, давхар, нэмэлт байдлаар тодрох туурвилзүй ажиглагдлаа.

НОМЗҮЙ

1. Галбаатар.Д. “Монголын уран зохиолын онол, түүхийн зангилаа асуудлууд” Уб., 2001 он
2. Батбаяр.Д. “Гар” өгүүллэгийн түүвэр, УХХЭХороо, Уб., 1965 он
3. Батбаяр.Д. “Жаргалын найман морь” өгүүллэгийн түүвэр, Уб., 1974 он
4. Батбаяр.Д. “Аниргүйн эрвээхэй” өгүүллэгийн түүвэр, Уб., 1983 он
5. Батбаяр.Д. “Тэнгэрийн царай” өгүүллэг, туужийн түүвэр, Уб., 1987 он
6. Батбаяр.Д. “Айсуй баярын зөн” өгүүллэгийн түүвэр, Уб., 1990 он
7. Батбаяр.Д. “Саахалтын нууранд ангир дуугарна” шилмэл тууж, өгүүллэгийн түүвэр, Уб., 2007 он
8. Билигсайхан.Ч. “Дарамын Батбаяр”, ХХ зууны монгол зохиолчид цуврал, 74-р дэвтэр, Уб., 2004 он
9. Билигсайхан.Ч. “Бичгийн мэргэдийн билгүүн товчоон”, Уб., 2009 он
10. Магсар.Ц. “Айсуй баярын зөн” өгүүлэл, “Ц.Мөнхийн дэг сургууль” Уб., 2009 он
11. “Монголын орчин үеийн уран зохиолын түүх”, III боть, Уб., 1998 он
12. “Монголын уран зохиолын дээж бичиг”, Хэл зохиолын хүрээлэн, Уб., 2012 он
13. Мөнхбаяр.Б. “Монголын уран зохиолын тайлбар толь”, Уб., 2011 он
14. Лувсанвандан.С. “Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудалд”, Уб., 1973 он

15. Лувсанвандан.С. “Өгүүллэгийг урлах эрдмийн асуудалд” өгүүлэл, “Монголын орчин үеийн уран зохиолын онол, түүхийн асуудалд”, Уб., 1973 он
16. Сампилдэндэв.Х. “Монголын шинэхэн үеийн яруу найргийн чиг хандлага” “Монголын утга зохиолын шүүмжийн улсын уралдаан”, Уб., 2006 он
17. “Утга зохиолын хөгжлийн асуудлууд”, Уб., 1971 он
18. “Утга зохиол шинжлэл”, МУБИС, утга зохиолын тэнхим, Уб., 2004 он

SUMMARY

This article discusses the characteristics of short stories by Batbayar Darma. He has made contributions to the development of Mongolian short stories through his special writing techniques. Most works showcase a traditional Mongolian way of thinking and express the author's inner philosophy.